

ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААН ДАХЬ ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ЖУРАМ

Зорилго: Хүүхэд хамгааллын тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасны дагуу эрүүгийн болон иргэний, гэр бүлийн, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахад оршино.

Үйл ажиллагаанд баримтлах зарчим: Хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчлийг хянан шийдвэрлэхэд хүүхэд хамгааллын зарчмаас гадна эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн эрх, дээд ашиг сонирхол, аюулгүй байдлыг нэн тэргүүнд тавих зарчмыг баримтална.

Үйлчлэх хүрээ: Хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэгч, бусад оролцогчдод энэ журмаар нэмэлт эрх, үүрэг тогтоохгүй бөгөөд гагцхүү тухайн ажиллагаанд хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах талаар журмыг тогтооно.

Хүүхэд, гэр бүлийн ажилтан, хүүхдийн эрхийн улсын байцаагч, өмгөөлөгч, улсын өмгөөлөгч, хууль ёсны төлөөлөгч, мөрдөгч, прокурор, шүүгч, Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо нь Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль болон түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний акт, энэ журмыг дагаж мөрдөнө.

Нэр томьёо: Энэхүү журамд хуулийн нэр, томьёог хэрэглэхэд хүчин төгөлдөр үйлчилж байгаа Монгол Улсын хууль, захиргааны хэм хэмжээний актаар тогтоосон нэр томьёоны тайлбарыг ашиглана. Тухайлбал, “эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд” гэдгийг Хүүхэд хамгааллын тухай хуульд зааснаар, “Хүүхдийн эсрэг гэмт хэрэг” гэдгийг Эрүүгийн хуульд зааснаар ойлгоно.

Нэг.Ерөнхий нөхцөл

1.1.Эрүү, иргэн, гэр бүл, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх, зөрчил шалган ажиллагааны явцад хүүхэд, гэр бүлийн ажилтан; хамтарсан багийн нийгмийн ажилтан; хүүхдийн эрхийн улсын байцаагч; өмгөөлөгч; улсын өмгөөлөгч; хууль ёсны төлөөлөгч; мөрдөгч; прокурор; шүүгч, шүүхийн захиргааны ажилтан; Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо; хамтарсан баг; хуулиар үүрэг хүлээсэн бусад хүн, хуулийн этгээд нь хүүхдийн эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах, хүүхэд хамгааллын үйл ажиллагаа явуулахад хамтран ажиллана.

1.2.Энэ журмын 1.1-т заасан субъект нь Хүүхэд хамгааллын тухай хуулийн 4.1.5-д заасан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч хүүхдийн дэдээшиг сонирхлыг хангаж, хүүхдийн талаар мэдээллийг харилцан солилцож, хүүхэд хамгааллын үйлчилгээнд хамруулахад хүчин чармайлт гарган ажиллана.

1.3. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад Хүүхэд хамгааллын тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1-т заасны дагуу мэргэжлийн удирдлагаар хангаж, хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан, хамтарсан багт мэргэжил арга зүйн туслалцаа, зөвлөгөө үзүүлж, Хүүхдийн эрхийн улсын байцаагч, ахлах байцаагч нь үйл ажиллагаанд хяналт тавина.

1.4. Хүүхдийн эрхийн улсын байцаагч, эрх бүхий албан тушаалтан, цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагч нь Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд заасны дагуу хүүхдээс үйлдсэн болон хүүхдийн эсрэг зөрчлийг шалган шийдвэрлэх ажиллагааны явцад эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг хүүхэд хамгааллын үйлчилгээнд хамруулна.

1.5. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан нь өсвөр насны сэжигтэн, яллагдагчийн хууль ёсны төлөөлөгчөөр хуульд заасан нөхцөл үүссэн тохиолдолд оролцоно. Хууль ёсны төлөөлөгч нь хүүхдийн эсрэг ашиг сонирхолтой эсхүл тухайн хүүхэдтэй таарамжгүй харилцаатай, хувийн мэдээллийг задруулах эрсдэлтэй бол татгалзан гаргах асуудлыг хуульд заасны дагуу шийдвэрлэж хүүхэд гэр бүлийн нийгмийн ажилтныг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хууль ёсны төлөөлөгчөөр оролцуулна.

1.6. Хүүхэд гэр бүлийн нийгмийн ажилтан эсвэл орон нутгийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан хүүхдийн байгууллагын хүүхэд хамгааллын мэргэжилтэн, хүүхдийн эрхийн улсын байцаагч нь харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд зөрчил шалган шийдвэрлэх болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд татагдан оролцож байгаа хүүхдийн нөхцөл байдлыг тодорхойлж, зөрчил, гэмт хэрэгт хохирсон, сэжиглэгдсэн, яллагдагчаар татагдсан хүүхдийн талаар цагдаагийн байгууллага болон прокурор, шүүхэд үндэслэл бүхий санал боловсруулж, шийдвэрлүүлнэ.

1.7. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд байгаа хүүхдийн талаарх мэдээллийг Хүүхэд хамгааллын тухай хуулийн 43 дугаар зүйлд зааснаар холбогдох эрх бүхий байгууллагад мэдээлэх бөгөөд хүүхдийн талаарх хувийн мэдээллийг нууцлах, олон нийтэд мэдээлэхгүй байх шаардлагатай арга хэмжээг авч ажиллана.

1.8. Эрүүгийн болон иргэний, зөрчил шалган шийдвэрлэх, гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх хуульд заасан үндэслэл, журмын дагуу тодорхой ажиллагааны, шүүхийн үе шатанд хүүхэд хамгааллын үйлчилгээг үзүүлэх ба хүүхэд гэр бүлийн нийгмийн ажилтан эсвэл орон нутгийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан хүүхдийн байгууллагын хүүхэд хамгааллын мэргэжилтэн, улсын байцаагч нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эрсдэлт нөхцөл байдалд байгаа хүүхдийн талаар авах арга хэмжээг боловсруулж, хэрэгжүүлнэ.

1.9. Энэ журмын 1.1-т заасан субъект нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байгаа хүүхдийн төрийн байгууллагын албан хаагч, ажилтан, мэргэжилтэн, төрийн бус байгууллагын мэргэжилтэн, нийгмийн ажилтантай хамтран ажиллана.

1.10. Энэ журмыг хэрэгжүүлэхэд 21 аймаг, 9 дүүрэгт байгуулагдсан Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо хариуцсан хүүхэд хамгааллын мэргэжилтэн, төрийн бүх шатны байгууллага, бусад байгууллага, албан тушаалтантай харилцана.

Хоёр.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч хүүхдийн талаар мэдээллийг солилцох

2.1.Хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг хэрэгжүүлэгч болох цагдаагийн албан хаагч, мөрдөгч, прокурор, шүүгч, өмгөөлөгч, улсын өмгөөлөгч, төрийн албан хаагч нь хүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч хүүхэд болох тогтоогдсон, тухайн ажиллагаанд хүүхэд бусад байдлаар татагдан оролцох нөхцөл үүссэн тохиолдолд харьяалсан нутаг дэвсгэрийн хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан эсвэл орон нутгийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан хүүхдийн байгууллагын хүүхэд хамгааллын мэргэжилтэн, улсын байцаагчид утсан харилцаа, амаар болон бичгээр мэдээлнэ.

2.2.Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан эсвэл орон нутгийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан хүүхдийн байгууллагын хүүхэд хамгааллын мэргэжилтэн, улсын байцаагч нь энэ журмын 2.1-т заасны дагуу ирүүлсэн мэдээллийн дагуу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч хүүхдэд Хүүхэд хамгааллын тухай хуульд заасны дагуу хүүхдийн эрсдэлийг үнэлж хүүхэд хамгааллын үйлчилгээний хэрэгцээ, шаардлагыг тодорхойлно.

2.3.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч хүүхэд нь эрсдэлт нөхцөлд байгаа нь тогтоогдсон бол хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үед оролцогч талууд нь хүүхдийг хүүхэд хамгааллын үйлчилгээ авах нөхцөл боломжоор хангана.

2.4.Энэ журмын 1.1-д заасан субъектэд нийтийн сүлжээ, хэвлэл мэдээллийн хэрэгслээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч хүүхдийн талаар дуу-дүрсний бичлэг, фото зураг зэргийг ашиглаж мэдээ, мэдээлэл, нийтлэл, ярилцлага зэргийг нэвтрүүлэхийг хориглоно.

2.5.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хүүхдийн эрх зөрчигдсөн, эсхүл эрсдэлт нөхцөлд байгаа талаар мэдээ, мэдээллийг хүлээн авсан хүүхдийн эрхийн тухайн мэдээллийг газар дээр нь шалгах, үнэлэх явцад хүүхдийн амь нас, эрүүл мэндэд аюул шууд учирсан, эсхүл уг нөхцөл бүрдсэн, хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчлийг түүний асран хамгаалагч үйлдсэн, хүүхдийг тухайн орчинд үлдээх боломжгүй нөхцөл үүссэн бол яаралтай түр тусгаарлах арга хэмжээг эрх бүхий албан тушаалтанд тавьж, шийдвэрлүүлнэ. Эрх бүхий албан тушаалтан гэдэгт шүүгч, прокурор, цагдаагийн алба хаагч хамаарна.

2.6.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд цагдаа, прокурор, шүүхийн байгууллагатай мэдээлэл солилцох явцад тодорхой шийдвэр, хамгаалах арга хэмжээ авах хүртэл хүүхдийн байгууллагын ажилтан, улсын байцаагч нь хуульд заасан боломжит арга хэмжээ буюу хараа хяналтад түр өгөх, түр хамгаалах байранд байрлуулах зэрэг арга хэмжээг гэр бүлийн бусад гишүүн, хууль ёсны төлөөлөгчтэй зөвшилцөн хэрэгжүүлнэ.

Гурав. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дах хүүхэд хамгаалал

3.1.Дараахь тохиолдолд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны, гэрч, хохирогч хүүхдийг хамгаалах шаардлагатай эсэхийг заавал, шалгаж тогтооно. Үүнд:

3.1.1.Гэмт хэргийн мэдээлэгч, гэрч, хохирогч өөрөө хүсэлт гаргаагүй ч тухайн этгээдийг айлган сүрдүүлж, хууль бусаар нөлөөлж байгаа талаарх баримт сэлт мэдээлэл байвал;

3.1.2.Гэр бүлийн хамаарал бүхий хүн, ойр дотны хүний эсрэг үйлдэгдсэн гэмт хэргийн мэдээлэгч, гэрч, тухайн хэргийн хохирогчийн мэдүүлэг хэргийг шийдвэрлэхэд голлох нөлөө үзүүлэхээр бол;

3.1.3.Албан тушаал бусад байдлаар эрхшээлдээ байгаа хүний эсрэг үйлдэгдсэн гэмт хэргийн гэрч, хохирогч хүүхдийн мэдүүлэг тухайн хэргийг шийдвэрлэхэд гол нотлох баримт болж байгаа тохиолдолд;

3.1.5.Зохион байгуулалттай үйлдэгдсэн гэмт хэргийн гэрч, хохирогч эсхүл урьд ял шийтгэгдсэн, хэрэгт яллагдагчаар татагдсан хүний хувийн байдал нь тухайн хэргийн гэрч, хохирогч хүүхдэд аюул учруулж, нөлөөлж болох эрсдэлтэй бол;

3.2.Гэмт хэргийн насанд хүрээгүй гэрч, хохирогчийг хамгаалах зайлшгүй шаардлага байгаа талаар баримт, мэдээлэл авагдсан, эсхүл тухайн хүүхэд өөрөө болон тухайн хүүхдийн болон хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчөөр дамжуулан ЭХХШТХ-д заасны дагуу аюулгүй байдлаа хамгаалуулахаар хүсэлт гаргасан бол аюулын зэргийн үнэлгээг заавал хийлгэнэ.

3.3.Аюулгүй байдлаа хамгаалах хүсэлт гаргаагүй боловч хуульд заасны дагуу хамгаалах зайлшгүй шаардлага үүссэн тохиолдолд цагдаагийн байгууллагын алба хаагч, мөрдөгч, прокурор нь насанд хүрээгүй гэрч, хохирогчтой биечлэн уулзаж тухайн арга хэмжээний ач холбогдлын талаар тайлбарлаж өгнө.

3.4.Насанд хүрээгүй гэрч, хохирогч мэдүүлгээсээ буцаж болзошгүй тохиолдолд хуульд заасан хамгаалалтын талаар тайлбарлаж, зөвлөгөө өгнө.

3.4.Гэмт хэргийн мэдээлэгч, гэрч, хохирогч хүүхдийг хамгаалахад ЭХХШТХ болон Гэрч хохирогчийг хамгаалах тухай хуулиас гадна тухайн гэмт хэрэг үйлдэгдсэн нөхцөл байдал, гэмт хэрэгт сэрдэгдэн шалгагдаж байгаа хүүхдийн хувийн байдлаас хамааран бусад хуульд заасан хамгаалалт, туслалцааг үзүүлнэ. Үүнд:

а/Гэр бүлийн хүчирхийлийн хохирогчид Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 31 дүгээр зүйлд заасны дагуу аюулгүйн зэргийн үнэлгээ хийж, мөн хуулийн 33 дугаар зүйлд заасан хамгаалалт, туслалцааг үзүүлэх.

б/гэр бүлийн хүчирхийллийн улмаас хохирсон хүүхдэд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн Дөрөвдүгээр бүлэгт заасан тусгай хамгаалалтаар хангаж, цаашид Хүүхэд хамгааллын тухай хуульд заасан хариу үйлчилгээнд холбон зуучилна.

в/Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид Хүн худалдаалах тухай хуулийн 11, 12, 13 дугаар зүйлүүдэд заасан хамгаалалт, тусламж үйлчилгээг үзүүлнэ.

3.5.Гэр бүлийн хүчирхийллийн мэдээлэгч, гэрч, хохирогч хүүхдийг хамгаалахад тухайн хууль болон Хууль зүй, дотоод хэргийн сайд, Улсын Ерөнхий прокурорын 2017 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн А/22, А/31 дугаартай тушаалаар хамтран баталсан “Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн аюулгүй байдлыг хангах журам”-ын дагуу ажиллаж шийдвэрлэнэ.

3.6.Таслан сэргийлэх арга хэмжээг зөрчиж гэрч, хохирогч хүүхдэд нөлөөлсөн, заналхийлсэн үйл баримт, сэлт нь цагдан хорих үндэслэл болохоос гадна Эрүүгийн

хуулийн 13.5 дугаар зүйлд заасан “Заналхийлэх”, мөн хуулийн 21.5 дугаар зүйлд заасан “Гэрч, хохирогч, орчуулагч, хэлмэрчид хууль бусаар нөлөөлөх” гэмт хэргийн шинжтэй эсэхийг заавал шалгана.

3.7.Цагдаагийн байгууллагын алба хаагч, мөрдөгч нь гэмт хэргийн шинжтэй дуудлага, мэдээллийг шалгах явцад хүүхэд гэмт хэргийн гэрч, хохирогч болох нөхцөл байдал илэрхий тогтоогдвол Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргаа, орон нутгийн байгууллагад заавал мэдэгдэж Хүүхэд хамгааллын тухай хуульд заасан, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд мөн эсэх, тухайн хуульд заасан тусламж үйлчилгээ шаардлагатай эсэхийг тогтоолгоно.

3.8.Гэмт хэргийн гэрч, хохирогч хүүхдэд 4.1.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 13.1 дүгээр зүйл, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ авна.

3.9.Гэрч, хохирогч хүүхдийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэрээс бусад биеийн байцаалтыг мөрдөн шалгах ажиллагааны тэмдэглэлд тусгахгүйгээр тусад нь бичиж битүүмжлэн хавтаст хэрэгт хавсаргана.

3.10.Гэрч, хохирогч хүүхдэд эрсдэл бүхий нөхцөл байдал үүсэх, сэтгэл зүйн байдалд нөлөөлөхөөр бол тухайн хүүхдийг шүүх хуралдааны танхимд байлцуулахгүйгээр харилцаа холбооны хэрэгсэл ашиглан шүүхийн хэлэлцүүлэгт оролцуулна.

3.11.Шүүгдэгчийг шүүх хуралдааны танхимд байгаа үед гэрч, хохирогч хүүхэд мэдүүлэг өгөхөөс татгалзсан, эсхүл түүнийг байлцуулах үед гэрч, хохирогч үнэнийг мэдүүлэхгүй байх нөхцөл байдал үүсч болохоор бол шүүгч нь ЭХХШТХ-ийн 13.1 дүгээр зүйлийн 3.3 дахь хэсэгт зааснаар шүүх хуралдааны танхимаас шүүгдэгчийг түр гаргах арга хэмжээ авна.

3.12.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч гэрч, хохирогч хүүхэд нь мэдүүлэг өгөхөд айдастай, сэтгэцийн эрүүл мэндийн байдалд нь сөрөг нөлөө учрахаар бол цагдаагийн алба хаагч, мөрдөгч нь хууль ёсны төлөөлөгч, асран хамгаалагч, өмгөөлөгчтэй зөвшилцөн түүний байгаа газар эсхүл хүүхдийн байгууллагын тусгайлан тохижуулсан өрөө, бусад газарт мэдүүлэг авна.

Гэрч, хохирогч хүүхдийг хамгаалах арга хэмжээ¹

Д/д	Арга хэмжээ	Хэрэглэх шийдвэр гаргах этгээд	Арга хэмжээ авах этгээд
1	тодорхой үйлдлийг хязгаарлах	прокурор, шүүгч	мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллага, албан тушаалтан
2	биечилсэн хамгаалалтад авах	прокурор, шүүгч	мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллага, албан тушаалтан

¹Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн 13.1, 13.2 дугаар зүйл

3	мэдээллийн нууцлалыг хангах	прокурор, шүүгч	мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллага, албан тушаалтан
4	нэг бүрийн тусгай хэрэгсэл болон тусгай техник хэрэгсэл, холбооны хэрэгслээр хангах	прокурор, шүүгч	мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллага, албан тушаалтан
5	нийтэд мэдээлэх мэдээллээс гэрч, хохирогчийг танихад ашиглагдаж болох нэр, хаяг, ажлын газар, мэргэжил, бусад баримт мэдээ, мэдээллийг нууцлах, өөрчлөх, арилгах	прокурор, шүүгч	мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллага, албан тушаалтан
6	нэрийг нь нууцалсан гэрч, хохирогчийн талаарх мэдээ, мэдээллийг хайх, задруулахыг хориглох	прокурор, шүүгч	мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллага, албан тушаалтан
7	шүүхээс тогтоосон хугацаанд мэдээллийг задруулахыг хориглох	прокурор, шүүгч	мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллага, албан тушаалтан
8	гэрч, хохирогчийн нэрийг ил болгон танилцуулах хүртэл гэрч, хохирогчид зохиомол нэр өгч хамгаалах	прокурор, шүүгч	мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллага, албан тушаалтан
9	гэрч, хохирогчийг шүүх хуралдааны танхимд байлцуулахгүйгээр харилцаа холбооны хэрэгсэл ашиглан шүүхийн хэлэлцүүлэгт оролцуулах	-	шүүгч
10	яллагдагч, шүүгдэгчийн өмгөөлөгчийг оролцуулж авсан гэрч, хохирогчийн мэдүүлгийн тэмдэглэл, дууны, дүрсний, дуу- дүрсний бичлэгтэй танилцах ажиллагааг гэрчийг байлцуулахгүйгээр хийх	-	шүүгч
11	шүүгдэгчийг шүүх хуралдааны танхимд байгаа үед гэрч, хохирогч мэдүүлэг өгөхөөс татгалзсан, эсхүл түүнийг байлцуулах үед гэрч, хохирогч үнэнийг мэдүүлэхгүй байх нөхцөл байдал үүсч болохоор бол шүүх хуралдааны танхимаас шүүгдэгчийг түр гаргах	-	Шүүгч

12	гэрч, хохирогчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэрээс бусад биеийн байцаалтыг мөрдөн шалгах ажиллагааны тэмдэглэлд тусгахгүйгээр тусад нь бичиж битүүмжлэн хавтаст хэрэгт хавсаргах	мөрдөгч	мөрдөгч
----	--	---------	---------

Дөрөв. Иргэний болон гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дах хүүхэд хамгаалал

4.1.Иргэний болон гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад тухайн хэрэгт хүүхдийг гэрч болон бусад хэлбэрээр оролцоход эрсдэл бүхий нөхцөл байдал үүссэн, гэр бүлийн гишүүдийн хооронд эд хөрөнгийн болон бусад маргааныг шийдвэрлэх явцад хүүхдийн эрх ашиг сонирхол зөрчигдөж болзошгүй тохиолдолд шүүгч, шүүхийн захиргааны ажилтан нь энэ журамд заасны дагуу тухайн хүүхдийн эрхийг хангах зорилгоор хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан эсвэл орон нутгийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан хүүхдийн байгууллагын хүүхэд хамгааллын мэргэжилтэн, улсын байцаагчид мэдэгдэнэ.

4.2.Иргэний болон гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад тухайн хүүхэд эрсдэлт нөхцөлд байгаа нь тогтоогдвол шүүгч нь хүүхэд хамгааллын тусламж, үйлчилгээ үзүүлэх боломжоор хангана.

4.3.Иргэний болон Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хүүхэд хамгааллын үйл ажиллагааг зогсоохгүй бөгөөд шүүхээс шийдвэр гаргахад хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан эсвэл орон нутгийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан хүүхдийн байгууллагын хүүхэд хамгааллын мэргэжилтэн, улсын байцаагч, Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны төлөөллийг хуульд заасны дагуу оролцуулна.

Тав. Үйл ажиллагаа, зохион байгуулалт

5.1.Энэ журмын хэрэгжилтийг хангах зорилгоор Хүүхэд, гэр бүлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, орон нутгийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан хүүхдийн байгууллага нь прокурор, Шүүхийн тамгын газар, цагдаагийн байгууллага, Хүүхдийн эрхийн хууль зүйн хороотой хамтран жил бүр хэлэлцэж, цаашид авах арга хэмжээг тодорхойлно.

5.2.Тухайн жилийн үйл ажиллагааны тайланд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд байгаа хүүхдийн ерөнхий мэдээлэл, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд, түүний шалтгаан нөхцөл, дүн шинжилгээ, хуульд заасны дагуу явуулсан үйл ажиллагаа түүний төрөл, явц, бусад байгууллагатай хамтран явуулсан үйл ажиллагаа, хяналт, зөвлөгөө өгсөн байдал, гаргасан шийдвэр зэргийг хэлэлцэнэ.

5.Энэ журмыг зөрчсөн эрх бүхий албан тушаалтан, мөрдөгч, прокурор, шүүгчид холбогдох гомдол хүсэлтийг шийдвэрлэх, түүнд хүлээлгэх хариуцлагыг

Төрийн албаны тухай хууль болон бусад хууль тогтоомж, ёс зүй, сахилгын хэм
хэмжээгээр зохицуулна.

----oOo----

ТӨСӨЛ